

*Бизнесийн амжилтын
түүхийг Хөгжлийн Шийдэл
хамт бичилсэнэ*



2016

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**



АГУУЛГА

04 МЭНДЧИЛГЭЭ	05 БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА	08 ҮЙЛ АЖИЛЛАГАА
12 REACH ТӨСӨЛ	15 ҮВМ ХӨТӨЛБӨР	17 LINKAGE ХӨТӨЛБӨР
18 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХУВИЙН БИРЖ	19 БИЗНЕСИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ	20 БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТӨВ
21 ТОГТВОРТОЙ БИЧИЛ УУРХАЙ ТӨСӨЛ	21 ХӨДӨӨ АЖ АХУЙН МАРКЕТИНГ ТӨСӨЛ	22 СУРГАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ
	23 BIZGUIDE.MN	25 ХАМТЫН АЖИЛЛАГАА

МЭНДЧИЛГЭЭ

Хөгжлийн Шийдэл ТББ нь Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж буй жижиг, дунд бизнесүүдийн тогтвортой хөгжил дэвшилд чиглэсэн бизнесийг дэмжих цогц үйл ажиллагаагаараа дотоод болон гадаадын хандивлагч байгууллагуудын дунд маш их эрэлттэй, нэр хүндтэй байгууллага болоод байна. Ялангуяа Монгол улсад энтрепренёр сэтгэлгээг түгээх, ажлын байраар иргэдийн амьдралын чанарыг нэмэгдүүлэх, бизнесүүдийн өрсөлдөх чадавхыг сайжруулах чиглэлээр олон улсад туршигдан амжилттай хэрэгжиж буй шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж ажилладагаараа өөрийн онцлогтой.

2016 онд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагтай хамтран жижиг, дунд бизнесүүдийн эзэлжих чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор REACH Төслийг эхлүүлэн ажиллаж байна. Энэ төслийн хүрээнд арилжааны банкнуудын зүгээс жижиг, дунд бизнесүүдэд зориулсан эзэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн тоо, төрөл нэмэгдэж, нөгөөтээгүүр бизнес эрхлэгчдийн хувьд өсөн нэмэгдэх санхүүгийн хэрэгцээгээ олж авах мэдлэг туршлага нь аривжиж байна.

2013 оноос эхлүүлсэн Залуусын Бизнесийг Дэмжих Санаачлага хөтөлбөрийн хүрээнд 100 гаруй залуу бизнес эрхлэгчид сайн дурын бизнес менторуудтай холбогдон ажиллаж байна. Энэхүү хөтөлбөрөөр дамжуулан бизнес менторингийн тухай ойлголтыг өргөн хүрээнд түгээж байна. Үүний зэрэгцээ залуус маань боломжит бизнес хамтрагч, түншлэгчтэй сарын тутмын зохион байгуулагддаг клубийн уулзалтуудаар холбогдохоос гадна туршлагатай менторуудын зөвлөмжийг сонсох, өөрсдийн санал бодлоо бусадтайгаа хуваалцах боломжуудаар хангагдаж байна.

Хөгжлийн Шийдэл ТББ-ын Удирдах Зөвлөлийн зүгээс тус байгууллагын хамт олны хараат бус, ёс зүйг эрхэмлэгч, харилцагч төвтэй зарчмын хүрээнд бий болгодог шинэлэг, үр дүнтэй шийдлүүдийг ямагт дэмжин ажилладаг бөгөөд цаашид бизнесийг дэмжин хөгжүүлэх олон улсын туршлага бүхий илүү олон сонирхолтой шинэлэг арга барил, мэдлэг, туршлагуудыг бүтээнэ гэдэгт итгэлтэй байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга
Бүдрагчаагийн Баяр

БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА



ТОВЧ ТҮҮХ

Хөгжлийн Шийдэл төрийн бус байгууллага нь шинэлэг, үр дүнтэй, шилдэг шийдлээр өрх гэрүүдийн амьдралын чанарыг сайжруулж, өсөлтөд чиглэсэн бизнесийн чадавхыг бий болгох, байгаль орчинд ээлтэй нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой нийгэмд үйлчилдэг байгууллага бөгөөд 2008 оны 8-р сарын 14-ний өдөр үүсгэн байгуулагдснаасаа хойш хэрэгжүүлж буй 64 төсөл, хөтөлбөрийнхөө хүрээнд харилцагч бүрийнхээ өсөлт, дэвшлийн хөшүүрэг нь болж, иргэд, бизнес эрхлэгчдийг дэмжих энтрепренёр сэтгэлгээ, хандлага, бизнесийн ур чадвар, борлуулалтын зах зээл, санхүүжилттэй холбох зэрэг олон талын цогц үйлчилгээг үр дүнтэй үзүүлж байна.

ХӨГЖИЛД ХӨТЛӨХ АЛСЫН ХАРАА

Хөгжлийн Шийдэл нь бизнесийн хөгжлийг дэмжих мэргэжлийн цогц үйлчилгээг үзүүлэгч шинэлэг, үр дүнтэй, шилдэг байгууллага байна.

НИЙГМИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО:

Хөгжлийн Шийдэл нь Шинэлэг, Үр дүнтэй, Шилдэг шийдлээр:

- Өрх гэрийн амьдралын чанарыг сайжруулна.
- Өсөлтөд чиглэсэн бизнесийн чадавхыг бий болгоно.
- Байгаль орчинд ээлтэй нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Хөгжлийн Шийдэл нь алсын хараатай, ашгийн бус, бие даасан Монголын төрийн бус байгууллага юм.
- Хөгжлийн Шийдэл нь харилцагч нэг бүрийн хэрэгцээнд тохирсон үнэ цэнэтэй, үр дүнд чиглэсэн бизнес хөгжлийн урт хугацааны цогц шийдлийг өргөн хүрээгээр үзүүлдэг.
- Манай байгууллагын ажилтан бүр үр дүнтэй хамтын ажиллагааг эрхэмлэдэг бөгөөд дэлхийд танигдсан бизнесийн хөгжлийн арга, туршлагаар Монголын бичил болон жижиг, дунд бизнесийн чадавхыг хөгжүүлэх ур чадвартай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Бүдрагчаагийн БАЯР
Удирдах зөвлөлийн дарга

Гүмэнжавын ЦЭВЭГЖАВ
Удирдах зөвлөлийн гишүүн

Гончигжанцангийн СУГАР
Удирдах зөвлөлийн гишүүн

Мандахын ЦЭНДЖАВ
Удирдах зөвлөлийн гишүүн

Цэрэнбямбаагийн БАТХҮҮ
Удирдах зөвлөлийн гишүүн



Хөгжлийн Шийдэл ТББ

БАЙГУУЛЛАГЫН ХАМТ ОЛОН

1	Эрдэнэбат БАТ-ОРШИХ	Гүйцэтгэх Захирал
2	Ренчинтогтох ХОС-ЭРДЭНЭ	Ерөнхий Нягтлан Бодогч
3	Батмөнх НАРАНГАРАВ	Туслах Нягтлан бодогч
4	Цогтбаяр УРАНЗАЯА	Туслах Нягтлан бодогч
5	Жаргалсайхан ТЭМҮҮЛЭН	Санхүү Захиргааны Ажилтан
6	Гомбосүрэн БАТЦОГТ	Жолооч
7	Сундуй ЦОГЖАРГАЛ	Жолооч
8	Даш БАЯРМАА	Үйлчилгээний Ажилтан
9	Найдансүрэн СЭР-ОД	Мэдээллийн Технологийн Ажилтан
10	Ганбаатар ОЮУНГЭРЭЛ	Мэдээллийн Зохицуулагч
11	Өсөхбаяр УЯНГА	Бизнес Холболтын Ажилтан
12	Лхагва ТӨГСБАЯР	Ерөнхий Менежер
13	Лхагвадорж АНХБАЯР	БЗСТ Менежер
14	Бат-Энх БАЯРЧИМЭГ	Бизнесийн Зөвлөх
15	Сосорбарам БЭРЦЭЦЭГ	Бизнесийн Зөвлөх
16	Пүрэвдорж АМАРМЭНД	Бизнесийн Зөвлөх
17	Гэлэгнамжил БОЛОРЦЭЦЭГ	БДТ Менежер
18	Эрдэнэбат БИЛГҮҮН-ОЧИР	Орчуулагч
19	Баатарцогт МӨНГӨНӨБАГАНА	Бизнесийн Зөвлөх
20	Жаргал ТЭМҮҮЖИН	Бизнесийн Зөвлөх
21	Бямбаа ХИШИГСҮРЭН	Төслийн Менежер
22	Манахмет ГҮЛДАУРЕН	Маркетинг Олон Нийттэй Харилцах Ажилтан
23	Эрдэнэбат ТУУЛ	Төслийн Ажилтан
24	Батсүх НОМИН-ЭРДЭНЭ	Төслийн Ажилтан
25	Ёндонжамц ЭНХ-АМГАЛАН	Төслийн Ажилтан
26	Батцоож ГАНГИС	Мониторинг Үнэлгээний Ажилтан
27	Ганцэцэг ОЮУН-ЭРДЭНЭ	Төслийн Ажилтан
28	Бахира АНАРГҮЛ	Төслийн Ажилтан
29	Пунцаг БАДАМЦЭЦЭГ	Төслийн Ажилтан
30	Энхбат СҮНЖИДМАА	Төслийн Ажилтан
31	Пүрэв АЗЖАРГАЛ	Төслийн Ажилтан

ҮЙЛ АЖИЛЛАГАА



БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

- ◆ YBM-Залуу Бизнесийг Дэмжих Санаачлага
- ◆ REACH-Жижиг, Дунд Бизнесийн Санхүүжилтийг Дэмжих Төсөл
- ◆ Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв
- ◆ Бизнесийн Холболтын Хөтөлбөр
- ◆ Жижиг, Дунд Бизнесийг Дэмжих Төв
- ◆ Бүлэг, Хоршооны Засаглалыг Дэмжих Хөтөлбөр
- ◆ Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Хувийн Бирж
- ◆ Ментор Хөтөлбөр



БИЗНЕСИЙН ЗӨВЛӨГӨӨ, ҮЙЛЧИЛГЭЭ

- ◆ Бизнесийн үнэлгээ, судалгаа
- ◆ Стратегийн удирдлага
- ◆ Маркетингийн удирдлага
- ◆ Зах зээлийн судалгаа
- ◆ Хүний нөөцийн удирдлага
- ◆ Менежмент
- ◆ Санхүү, нягтлан бодох бүртгэл
- ◆ Зээлийн зуучлал
- ◆ Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих загварчлал




СУРГАЛТ, СЕМИНАР

- ◆ Бизнесийн сургалт
- ◆ Зөв эхлэл, цогц мэдлэг
- ◆ Зээлдэгчийн боловсрол
- ◆ Анхан шатны нягтлан бодох бүртгэл
- ◆ Санхүүгийн тайлан бэлдэх, унших
- ◆ Бизнесийн төсөл, төлөвлөгөө боловсруулах
- ◆ Өрхийн төсөв
- ◆ Хүүхдийн санхүүгийн боловсрол
- ◆ Байгууллагын сургалт
- ◆ Гайхалтай үйлчилгээ
- ◆ Шилдэг ажилтан
- ◆ Ажилтнаа тогтоон барих аргууд
- ◆ Борлуулалтыг өсгөх сэтгэлгээний өөрчлөлт
- ◆ Мэдээлэл солилцооны үнэ цэнэ
- ◆ ТББ-ын менежмент
- ◆ Бизнесийн бүлэг, хоршоодын менежмент




БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД

/2016 оны 12 сарын 31-ний байдлаар/



БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАРИЛЦАГЧДЫН ӨГСӨН ҮНЭЛГЭЭ



Хөгжлийн Шийдэл ТББ-аас үйлчилгээ авсан харилцагчдын сэтгэл ханамж

54% **46%**
Маш Сайн Сайн

Хөгжлийн Шийдэл ТББ-ын ажилтны ур чадвар, харилцаа хандлага

54% **40%** **4%**
Маш Сайн Сайн дунд

Хөгжлийн Шийдэл ТББ-ын үйлчилгээний үр дүнд харилцагчдын бизнес эсхүл байгууллагын үйл ажиллагаанд ямар нэгэн эерэг өөрчлөлт бий болсон

69%

БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

REACH-ЖИЖИГ, ДУНД
БИЗНЕСИЙН САНХҮҮЖИЛТИЙГ
ДЭМЖИХ ТӨСӨЛ

УВМ-ЗАЛУУ БИЗНЕСИЙГ
ДЭМЖИХ САНААЧЛАГА

LINKAGE- БИЗНЕС
ХОЛБОЛТЫН ХӨТӨЛБӨР

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ ХУВИЙН БИРЖ

ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТӨВ

ХӨДӨӨ АЖ АХУЙН МАРКЕТИНГ ТӨСӨЛ

ТОГТВОРТОЙ БИЧИЛ УУРХАЙ ТӨСӨЛ

REACH-ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ



АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн зүгээс Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран жижиг, дунд бизнесүүдийг санхүүгийн хувьд илүү бат бөх, тогтвортой үйл ажиллагаатай болоход шаардлагатай санхүүжилтийг банк, санхүүгийн байгууллагаас олж авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор REACH Төслийг хэрэгжүүлж байна.

Энэхүү төслийн зорилго нь олон бэрхшээлүүдээс шалтгаалан банк, санхүүгийн байгууллагаас санхүүжилт авч чаддаггүй жижиг, дунд бизнесүүдэд хэрэгцээтэй зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ авах боломж, чадавхыг нь нэмэгдүүлэхэд оршино.

ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

- Жижиг, дунд бизнесийн санхүүжилтэд хамрагдах ур чадварыг хэрэгцээг тодорхойлох;
- Бизнесийн зээлийн бичиг баримтын бүрдүүлэлтэд дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- Жижиг, дунд бизнесийн санхүүжилтэд төр болон хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох;
- Төслийн 5 салбар нэгжээс зээлийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх;
- “Жижиг, дунд бизнесийн санхүүжилт” форум зохион байгуулах;

Төсөл хэрэгжих байршлууд:

Улаанбаатар хот, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Сэлэнгэ аймаг

Төсөл хэрэгжих хугацаа

2016.05-2018.04 сар



REACH ТӨСЛИЙН ҮР ДҮН

/2016 оны 12 сарын 31-ний байдлаар/

178

Амжилттай зуучилсан
зээлийн тоо

20,08
тэрбум ₮

Зуучилсан зээлийн хэмжээ

70

Бизнесийн сургалт

24

Үйл ажиллагаа болон
ажил хэрэгч уулзалт

1,858

Зөвлөх үйлчилгээ
үзүүлсэн цаг

Бизнесийн хэлбэр:

52%

Аж Ахуйн Нэгж

48%

Хувиараа бизнес
эрхлэгчид

Байршил:

55%

Улаанбаатар
хот

45%

Төсөл хэрэгжиж
буй аймгууд

Хүйс:

37%

Эрэгтэй бизнес
эрхлэгчид

63%

Эмэгтэй бизнес
эрхлэгчид





REACH ТӨСЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛСАН ТОМООХОН ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

Улаанбаатар хот

- 7.29.2016 “Тогтвортой санхүүжилтэд хамрагдах шинэ боломжууд” ажил хэрэгч уулзалт
- 8.18.2016 “Бизнесийн зээлийн боломжууд” ажил хэрэгч уулзалт
- 8.25.2016 “Зээлийн батлан даалтын санд хамрагдах боломжууд” ажил хэрэгч уулзалт
- 9.12.2016 “Үр ашигтай зээлийн зуучлал” ажил хэрэгч уулзалт
- 9.15.2016 “Бизнесийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн Бизнесийн эрсдэлийн менежмент, аргачлал ба боломжууд” ажил хэрэгч уулзалт
- 9.30.2016 “Татвар төлөхийн ач холбогдол: НӨАТ, Татварыг бууруулах таатай боломжууд” ажил хэрэгч уулзалт
- 10.5.2016 “Жижиг, дунд үйлдвэрүүдийг даатгалд хамруулах харилцаа” ажил хэрэгч уулзалт
- 10.20.2016 “Интернет маркетинг ба технологийг ашиглан зээлд хамрагдах нь” ажил хэрэгч уулзалт
- 10.26.2016 “ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСҮҮДИЙН ЗЭЭЛЖИЛТИЙГ ДЭМЖИХ ФОРУМ-2016”
- 11.29.2016 “Хөрөнгө оруулалтад хамрагдах бизнесийн боломжууд” ажил хэрэгч уулзалт
- 11.17.2016 “Жижиг, дунд үйлдвэрүүд банкнаас санал болгож буй бүтээгдэхүүнүүдэд хамрагдах боломжууд” ажил хэрэгч уулзалт
- 12.13.2016 “Бизнесийн өсөлтийг зөв хөгжүүлэх стратегийг тодорхойлох нь” ажил хэрэгч уулзалт

Баян-Өлгий аймаг

- 10.5.2016 “Жижиг, дунд үйлдвэрүүдийн зээлд хамрагдах боломж” ажил хэрэгч уулзалт
- 12.9.2016 “Гар урлалын бизнес эрхэлдэг жижиг, дунд үйлдвэрүүдийн зээлд хамрагдах боломж” үзэсгэлэн

Дорнод аймаг

- 10.23.2016 “Татвар төлөхийн ач холбогдол” ажил хэрэгч уулзалт

Дундговь аймаг

- 11.23.2016 “Жижиг, дунд үйлдвэрүүдийн зээлд хамрагдах боломж” ажил хэрэгч уулзалт

Сэлэнгэ аймаг

- 11.11.2016 “Жижиг, дунд үйлдвэрүүдийн зээлийн батлан даалтын үйлчилгээнд хамрагдах боломж” ажил хэрэгч уулзалт

ҮБМ-ЗАЛУУ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ САНААЧЛАГА ХӨТӨЛБӨР

ybi | Youth
Business
International

YOUTH
BUSINESS
MONGOLIA
Залуу бизнесийг дэмжих санаач

Хөгжлийн Шийдэл ТББ нь 2013 онд Лондон хотод төвтэй Youth Business International Олон улсын байгууллагын гишүүнээр элсэн Залуусын Бизнесийг Дэмжих Санаачлага хөтөлбөрийг Монгол улсад хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь 18-35 насны залуусыг нийгмийн энтрепенёр болгон хөгжүүлж бизнес эхлэх болон эрхлэхэд дэмжин ажиллах зорилготой юм.

ҮБМ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРЬЖ БУЙ ҮР ДҮН

- Ажил хэрэгч нийгмийн энтрепенёр залуус
- Ментортой залуу бизнес эрхлэгчид
- Мэдлэг, туршлага, инноваци, хамтын үнэ цэнэ

ҮБМ ХӨТӨЛБӨР 2016 ОНД

1,000

ЗАЛУУСТ ХҮРЧ

99

ШИНЭЭР БИЗНЕС
БИЙ БОЛЖ

276

ЗАЛУУ БИЗНЕС
ӨРГӨЖИН САЙЖИРЧ

120

БИЗНЕС МЕНТОР
БЭЛТГЭЖ

692

ЗАЛУУСЫГ БИЗНЕСИЙН
МЭДЛЭГ,
УР ЧАДВАРТ СУРГАЖ

72 сая ₮

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ГАДААД ЗАХ ЗЭЭЛЭЭС
БОСГОСОН



2016 онд Youth Business Mongolia хөтөлбөр нь Youth Business International ОУ-н төв байгууллагаас энтрепренёршипийн сургагч багшийн ур чадвар, насанд хүрэгсдийн суралцах аргазүйн чиглэлээр АРОЕНА-МАСТЕР СУРАГЧ БАГШ БЭЛТГЭХ сургалтыг өөрийн орондоо амжилттай зохион байгууллаа.



Энэхүү сургалт цаашид Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй Залуу Бизнесийг Дэмжих Хөтөлбөрөөс гадна бусад бизнесийн сургалтын арга зүйг олон улсын түвшинд хөгжүүлэх боломжийг олгосон. Энэхүү сургалтаар Монголын аж ахуйн нэгжүүдийн Хүний нөөцийн ажилтанууд хамрагдаж нийт 10 гаруй бизнесийн зөвлөх, сургагч багш нар АРОЕНА-МАСТЕР СУРАГЧ багш боллоо.



LINKAGE- БИЗНЕС ХОЛБОЛТЫН ХӨТӨЛБӨР

2016 ОНЫ БАЙДЛААР

1,117

ТЭРБУМ ₮

БОРЛУУЛАЛТЫН
ХЭМЖЭЭ

192

ХАРИЛЦАА
ХОЛБОО
ТОГТООСОН
БАЙГУУЛЛАГА

1,330

ХАРИЛЦАГЧИЙН
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ТАНИЛЦУУЛГА,
БОРЛУУЛАЛТ


89

ХАМТРАН
АЖИЛЛАСАН
БАЙГУУЛЛАГА

56


ОРОЛЦСОН
ҮЗЭСГЭЛЭН
ХУДАЛДАА

НИЙТ ХАРИЛЦАГЧИД



- Өрх толгойлсон бизнес эрхлэгч эмэгтэйчүүд
- Жижиг дунд бизнес эрхлэгчид
- Залуу бизнес эрхлэгчид

НИЙТ БОРЛУУЛАЛТ ХИЙГДСЭН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН



- Ажлын хувцас, уул уурхай болон үйлдвэрлэлийн салбарын онцлог бүхий ажлын хувцаснууд
- Гар урлалын бүтээгдэхүүн
- Модон эдлэл монгол гэрийн тавилга болон монгол гэр

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХУВИЙН БИРЖ

“Хөгжлийн шийдэл” ТББ-н дэргэдэх Хөдөлмөрийн хувийн бирж нь ажилд орохыг хүссэн ажилгүй, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг биеэр, интернет /www.bizguide.mn/ болон утсаар мэдээллийн нэгдсэн сандаа бүртгэн авч, ажил олгогчийн эрэлт хэрэгцээг үндэслэн хөдөлмөр зуучлалын үйлчилгээ үзүүлж байна.

80

АЖИЛ ОЛГОГЧ
БАЙГУУЛЛАГАТАЙ
ХАМТЫН АЖИЛЛАГАА

1896

АЖЛЫН БАЙРНЫ
ЗАХИАЛГА

689

АЖИЛ ХАЙГЧИЙН
БҮРТГЭЛ

185

АЖИЛ ХАЙГЧИЙГ
БАЙНГЫН БОЛОН
ТҮР АЖЛЫН
БАЙРАНД ЗУУЧЛАЛ



450

АЖИЛ ХАЙГЧИД
ЗӨВЛӨГӨӨ

112

АЖИЛ ХАЙГЧ
ЗӨВЛӨГӨӨ СУРГАЛТ

9

АЖИЛ ХАЙГЧ
ШИНЭЭР АЖЛЫН
БАЙРЫГ ӨӨРТӨӨ БИЙ
БОЛГОХ



БИЗНЕСИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



Хөгжлийн Шийдэл ТББ нь Бизнесийн зөвлөх үйлчилгээгээр дамжуулан байгууллагын одоогийн нөхцөл байдлыг үнэлэн, тулгарч буй асуудлыг илрүүлж, оновчтой, ашигтай, хувилбараар шийдвэрлэх аргачлалуудыг санал болгож, хэрэгжүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлж байна.



22

БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТ



12

БИЗНЕС ТӨСӨЛ



25

БИЗНЕС ЗӨВЛӨГӨӨ




21

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА,
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА БОЛОН
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД СТРАТЕГИЙН
ЗӨВЛӨГӨӨ



34

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ,
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ХУДАЛДАН
АВАЛТЫН БИЧИГ БАРИМТ
БҮРДҮҮЛЭЛТ



БНСУ-ын КОЙКА байгууллагын санхүүжилтээр Азийн сан, Нийслэлийн төр захиргаа, Хөгжлийн Шийдэл ТББ, Монголын Үндэсний Худалдаа Аж үйлдвэрийн танхим, Голомт банк болон Голомт Секюритиз ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй гурван жилийн хугацаатай хэрэгжих туршилтын төсөл юм.

Энэхүү төвийн үйл ажиллагаа нь хотын эдийн засгийн хөгжилд эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгыг хангах болно. Хөгжлийн Шийдэл ТББ нь энэхүү төвийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулах, сургалт, зөвлөх, менторингийн холболтын үйлчилгээг хариуцан ажиллаж байна.



Төвөөр үйлчлүүлэгчид:

691 Бизнесийн ур чадвар олгох сургалт 

263 Бизнесийн зөвлөгөө 

626 Сургалт/үйлчилгээнд чиглүүлэх сургалт 

260 Хамтын оффис 

100 Бизнес номын булан 

30 Мэдээллийн үйлчилгээ 

12 Хүүхдийн булан 

39 Менторингийн холболт 

14 Бэлтгэгдсэн ментор 

ХӨДӨӨ АЖ АХУЙН МАРКЕТИНГ ТӨСӨЛ

LAMP-Хөдөө Аж Ахуйн Маркетингийн Төсөлд Хөгжлийн Шийдэл ТББ мэргэжлийн зөвлөх үйлчилгээний багаар ажиллав.




ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН ЯАМ

ТӨСЛИЙН ҮР ДҮНД

- Орон нутгийн **448** хүнд хүрч
- Нийт **34** хөрөнгө оруулалтын төслийг батлуулж
- Нийт **1,6** тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхэд туслав.

Бизнес төлөвлөлт сургалт	47
Байгаль орчны менежментийн төлөвлөлт хийлгэсэн	38
Мал үржлийн зөвлөгөө авсан	18
Тариалалтын зөвлөгөө авсан	62
Архангай демо сургалт авсан	16
Мал эмнэлэгийн сургалт	202
Мал үржлийн сургалт	65
НИЙТ	448



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Тэжээл
- Мал аж ахуй
- Хүнсний ногоо
- Мал эмнэлэг

ТОГТВОРТОЙ БИЧИЛ УУРХАЙ ТӨСӨЛ

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг


ТӨСЛИЙН ХҮРЭЭНД:

- **900** бичил уурхайчдын мэдээллийн санг бий болгож,
- **8** Бичил уурхайн ТББ-ын үйл ажиллагааг дэмжиж,
- **10** Бичил уурхайн ТББ-ын 150 бичил уурхайчдад төсөл бичих сургалтыг зохион байгуулж,
- Бичил уурхайчдын **1** ТББ-ыг Монголд төдийгүй Ази тивд анх олон улсын Шудрага Олборлолтын стандартыг нэвтрүүлж, гэрчилгээжүүлэлтийн үнэлгээнд бэлдэж, зөвлөгөө өгсөн.



СУРГАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Хөгжлийн Шийдэл ТББ нь 2011 оноос эхлэн байгууллагын ажилтануудад зориулсан сургалтыг зохион байгуулж байгаа бөгөөд сургалтын зорилго нь байгууллагын ажилчдын ур чадвар, идэвхи зүтгэл, эерэг хандлагыг нэмэгдүүлэн бүтээлч, үр дүнд чиглэсэн хамт олныг бий болгоход оршино.



- Гайхалтай үйлчилгээ- 40%
- Хандлага харилцаа- 20%
- Ёсзүй байгууллагын соёл- 7%
- Борлуулалтын хүч- 20%
- Бүтээлч манлайлал-13%



17

СУРГАЛТАД ХАМРАГДСАН
БАЙГУУЛЛАГА



635

СУРГАЛТАД ХАМРАГДСАН
АЖИЛТНУУД



77

СУРГАЛТЫН НИЙТ
ЦАГ



69%

СУРГАЛТАД
ХАМРАГДСАН НИЙТ
ЭРЭГТЭЙ АЖИЛТНУУД



31%

СУРГАЛТАД
ХАМРАГДСАН НИЙТ
ЭРЭГТЭЙ АЖИЛТНУУД



BIZGUIDE.MN

Bizguide.mn сайт нь бизнесийн байгууллагууд, жижиг дунд бизнес эрхлэгчид, бизнес эрхлэхээр төлөвлөж байгаа иргэдийг бизнес зөвлөгөө, мэдээллээр чиглүүлэх зорилготой. Түүнчлэн мэргэжлийн бизнес зөвлөхүүдийн мэдээлэл, зөвлөгөөн дээр тулгуурласан зайнаас зөвлөх, бие даан хөгжих боломжийг олгох юм.

ИДЭВХИТЭЙ ХЭРЭГЛЭГЧ

44

ӨДӨРТ

876

7 ХОНОГТ

2,261

14 ХОНОГТ


6,364

30 ХОНОГТ

БИДНИЙ ЗОРИЛТ

- Бизнесийн нэгдсэн мэдээллийн санд мэдээ мэдээллийг төвлөрүүлэх
- Иргэдийг бизнес мэдлэгийн нээлттэй хүртэх боломжоор хангах, тэдний цагийг хэмнэх
- Бизнес эрхлэлчдэд цахим мэдээллийн нэгдсэн сайтаар дамжуулах цахим мэдээллийн соёл, бизнестээ ашиглах дадлыг хэвшүүлэх, чадавхжуулах
- Жижиг дунд бизнес эрхлэгч болон бизнес эрхлэхээр төлөвлөж байгаа иргэдийг бизнесийн хэрэгцээт мэдлэг болох мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах

2016 ОНЫ САЙТЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



■ Шинэ хэрэглэгч
■ Байнгын хэрэглэгч

75,565

НИЙТ ЗОЧИД

21,265

БҮРТГЭЛТЭЙ ХЭРЭГЛЭГЧ

1,577,145

НИЙТ ҮЗСЭН ХУУДАСНЫ ТОО



BIZGUIDE.MN

BIZGUIDE

Бидний тухай | Холбоо барих | Монгол English

🔍 Сайтаас хайлт хийх...

Бизнес эхлүүлэх

Ажлын байрны зохион
байгуулалт

Санхүүгийн шийдэл

Маркетинг

Мэдээлэл технологи

Хүний нөөц

Хууль эрхзүй

Ногоон бизнес

Бизнес эмэгтэйчүүд

Нэвтрэх Бүртгүүлэх

f g

БИЗНЕС ТӨСӨЛ
БИЧИХ АПП

Бяцхан санхүүч
ТООЦООНЫ ДЭВТЭР

ХӨГЖЛИЙН
ШИЙДЭЛ

Жинхэнэ оюунлаг бэлэг- БЯЦХАН САНХҮҮЧ тооцооны дэвтэр
Та хүүхдээ багаас нь мөнгөтэй зов харьцуулж сургамаар байна уу ?
Тэгвэл танд БЯЦХАН САНХҮҮЧ тооцооны дэвтэр тусална.
Бяцхан санхүүч тооцооны дэвтрийн үнэ Ердөө л : 2 200 төгрөг
Захиалах холбоо барих: 88650861